

ХАР СҮҮДРЭЭС ГИЙСЭН ГЭРЭЛ ГЭГЭЭ
---- “Сүүдэр” уран сайхны киноны тухай ----

Окада Казуюки¹

Өмнөх үг

Халхын голын дайны тухай уран сайхны анхны кино бол 1936 онд Дорнодын хил хязгаарт халдан довтолсон Японы түрэмгийлэгчдийн эсрэг байлдаанд гавьяа байгуулсан Монгол улсын баатар Шагдарын Гонгорын (1912-1992) эрэлхэг үйл хэргийг дүрсэлсэн кино “Анхдугаар хичээл (Анхны хичээл)” (1940) гэж үзэж болно. Дараа нь 1942 онд “Аймшиггүй эх оронч”, “Хил дээр гарсан хэрэг” хэмээх хоёр киног бүтээж, өнөөг хүртэл “Дайсны цэргүүдээ сонсоцгоо” (1971), “Нар хиртсэн жил” (1974), “Говь Хянганд тулалдсан нь” (1981), “Зарлаагүй дайны оршил” (1984), “Байлдааны даалгавар” (1985) зэрэг Халхын голын дайны холбогдолтой арван тав зургаан уран сайхны киног бүтээсэн байна⁽¹⁾. Ийм уран сайхны киноны нийтлэг шинж чанар нь Халхын голын дайны түүхэн бодит үнэнийг чанд баримталж бүтээсэнд оршино гэж хэлж болно. Ялангуяа “Анхдугаар хичээл (Анхны хичээл)” киноны гол дүрд Ш.Гонгорыг өөрийг нь тоглуулсан баримтат киноны хэлбэртэй бөгөөд киног зохиож найруулсан Төмөрийн Нацагдорж⁽²⁾ (1910-1966) үнэн хэрэг дээрээ үзсэн эсэх нь тодорхойгүй байгаа боловч, Октябрийн хувьсгалд биеэрээ оролцсон хүмүүсийг дайчлан 1928 онд хуучин Зөвлөлтийн нэрт кино найруулагч Сергей Михайлович Эйзенштейний (1898-1948) бүтээсэн “Октябрь” кинотой арга барилын хувьд төстэй кино гэж үзэж болох талтай.

Тус өгүүлэлд дурдах гэж байгаа уран сайхны кино “Сүүдэр” (1986) ч Халхын голын дайны сэдэвтэй киноны нэг юм. Энэ удаа тус киног авч үзэх болсон учир нь уг киноны видео хуурцаг, монтажийн хуудас хоёрыг олж чадсан⁽³⁾ учир шалтгаан байгаагаас гадна тус кинонд урьдын дайны сэдэвтэй кинонуудад байгаагүй шинэлэг хандлага байгаа нь бас нэг учир шалтгаан нь болж байгаа юм. Ингээд тус киноны тухай агуулгыг нь танилцуулж, эргэцүүлэн бодож үзье.

1. Киноны гол дүрүүд, кино бүтээсэн бүрэлдэхүүн

1986 онд Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч Сорогдогийн Жаргалсайхан (1957-2007) зохиолыг нь бичиж, Монгол улсын төрийн шагналт кино оператор-найруулагч Бэгзийн Балжиннямын (1943-) найруулсан “Сүүдэр” хэмээх уран сайхны кино анх нийтийн хүртээл болсон юм. Халхын голын дайны хүнд хэцүү дурсамжийг

¹ Доктор, профессор. Япон улсын Токиогийн Гадаад судлалын их сургууль.

сэтгэлдээ хадгалж явдаг гол баатар Дугарын дүрд Монгол улсын гавьяат жүжигчин Гомбын Равдан (1952-), Халхын голын байлдааны талбарт зуурдаар нас барсан нэг нутгийн найз Өлзийгийн дүрд Монгол улсын төрийн шагналт жүжигчин Цэгмэдийн Төмөрбаатар (1956-), нөхөр Өлзийг нас барсны дараа Дугартай эр эмийн харилцаа тогтоож, хөл хүндтэй болсон эхнэр Цэвэлийн дүрд жүжигчин Доржийн Долгорсүрэн (1958-), Өлзий, Цэвэл хоёрын ганц хүү бөгөөд Дугарыг үзэн ядах Сандагийн дүрд Т.Отгонбаатар нар тоглосон байна⁽⁴⁾.

Мөн киноны ерөнхий оператороор Б.Балжинням, Дэчинравдангийн Балчинпүрэв (1950-) хоёр, ерөнхий зураачаар Пунцагийн Сосорбарам (1947-), хөгжмийн зохиолчоор Монгол улсын төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Нацагийн Жанцанноров (1948-), зөвлөхөөр хуучин “Манж Го” улсын цэргийн хурандаа байсан Монгол улсын гавьяат багш, МУИС-ийн хүндэт профессор Ядамсүрэнгийн Шаарийбуу (1909-2009) нарын алдартай хүмүүс ажилласан байна⁽⁵⁾.

2. Киноны товч үйл явдал

Халхын голын дайнаас нутагтаа эргэж ирсэн Дугар тарвага агнаад арай ядан амь зууж байна. Өөдгүйгээсээ болж багын найз Өлзийг Халхын голын дайны талбарт үхүүлсэн гэж өөрийгөө зэмлэж явна. Түүний ой тойнд Халхын голын дайны аймшигт бузар дурсамж байн байн сэргэж ирнэ. Дугар нутагтаа буцаж ирсний дараа талийгаач Өлзийгийн эхнэр бөгөөд бас багын найз байсан Цэвэлтэй эр эмийн харилцаа тогтооно. Цэвэл ч өөрөө дэндүү ичгүүр сонжуургүй явдал болохыг мэдэрч байсан боловч эр хүний тус дэм хэрэгтэй байсан учраас Дугартай харилцаагаа үргэлжлүүлнэ. Цэвэлийн аав ээж хоёр ч, түүний ганц хүү Сандаг ч анхандаа тэр хоёрын харилцаа холбоог хүлээн зөвшөөрөхгүй, авир явдлыг нь шийдэмгий буруушааж зэмлэнэ. Гэтэл Цэвэлийг хөл хүндтэй болсныг мэдэж аав ээж хоёрын байдал төлөв аажмаар зөөлөрч эхлээд тэдний харьцааг зөвшөөрөх болно. Харин Дугарыг үзэн яддаг хүү Сандаг л тэр хоёрын харьцааг даанч хүлээн зөвшөөрөхгүй, эсэргүүцэх зан авираа гаргасаар л байна. Тэгээд сүүлдээ Дугарын өөдөөс “Чи миний аавыг яах гэж хаяж явсан. Чи бүр зориуд хаяж явсан, мэдэв үү. Би чамайг сайн мэдэж байна. Чи миний аавыг алсан, мэдэв үү. Тэгээд манай ээжтэй сууж манай гэрийн эзэн болох гэснээ мэдэж байна уу, чи? ... Би чамайг гэртээ яасан ч оруулахгүй. Яасан ч оруулахгүй.”⁽⁶⁾ гэж шууд хэлнэ. Дугар сэтгэл зүрхэндээ хүнд цохилт авч Сандагийг орхиж, модны дэргэд очин өөрийгөө зэмлэн уйлна.

Цас орох өвлийн өглөө Сандаг дөнгөж сая төрсөн нялх дүүгээ тэвэрч байна. Энэ үеэс Сандагийн сэтгэл санаанд аажмаар өөрчлөлт гарч эхэлнэ. “Ямар хөөрхөн юм бэ! Би Дугар гуайнд очиж хэлчихээд ирье. Тэгэх үү?”⁽⁷⁾ Сандаг ийнхүү Дугарыг хүлээн зөвшөөрөх болсон байна. Гэтэл алга болсон нохойгоо эрэхээр ой модонд явсан Сандаг, ангийн буугаар амиа хорлох гэж байсан Дугарыг санамсаргүй олж авна. Сандаг амь насаа хайхралгүй Дугараас буугий нь булаан авч уйлангаа Дугарыг чирж явна. “Та чинь яаж байнаа? Дугар ахаа!”, “Намайг орхи. Боль. Тавиач ээ.”, “Дугар ахаа! Та чинь яаж байна? Дугар ахаа! Гэртээ харья л даа. Гэртээ харья. Та яаж байна?”⁽⁸⁾ Цастай талаар ноцолдож холдож яваа хоёр хүний үзэгдлийг доороос дээшээ нүүх аппаратаар авснаар кино төгсөнө.

3. Киноны дурсамжийн үзэгдлүүд




“Сүүдэр” киноны эхлэлийг үзсэн үзэгчид энэ киног дайны тухай кино юм гэж ойлгох байх. Киноны гарчиг, гол дүрүүд, киног бүтээгч бүрэлдэхүүний нэрс дэлгэцэнд гарсны дараа үзэгчид рүү хандаж буугаа шагайж байгаа эрийг (Дугар) томсгож авсан үзэгдэл гарч ирнэ. Дараагийн дэлгэц нь япон цэргийн элсэн манхан дээр жагсаж яваа үзэгдэл болж гэнэт бууны дуу цуурайтана. Гэтэл энэ буун дуу Дугарыг тарвага агнаж байгаа үед гарсан болохыг үзүүлэн бодит байдал даруй тодорч ирнэ. Өөрөөр хэлбэл энэ япон цэргийн жагсаалын үзэгдэл Дугарын өнгөрсөн үеийн дурсамжийн доторх үйл явдал болохыг сануулна. Өнгөрсөн үйл явдлыг одоогийн үйл явдалд хавчуулах арга барилыг (flashback) их хэрэглэсэн тус кино Дугарын өнгөрсөн дайны дурсамж, одоогийн бодит байдал хоёрыг зэрэгцүүлж өрнөнө. “Сүүдэр” шиг Дугарыг дагаж зууралдах дайны аймшигт муухай дурсамж киноны бодит үйл явдалд “flashback” аргаар гэнэт гэнэт хавчуулагдана. Иймэрхүү Халхын голын дайны холбогдолтой дурсамжийн үзэгдэл бүгд 86 минутын хугацаатай тус кинонд 10 удаа буюу 15 минут 34 секунд бий. Түүний агуулга, цагийг хүснэгт хийж үзүүлбэл ийм буюу.

Дугаар	Товч агуулга	Цаг (мин.сек.)
1	Элсэн манхан дээр жагсаж яваа япон цэрэг	14 сек.
2	Дугар, Өлзий нарыг цэрэгт зарлан дуудаж, бүртгэж, үдэж мордуулна.	1 мин. 54 сек.
3	Дугарын зүүдэнд орох үхэх гэж байгаа Өлзийгийн улаан нялга болсон нүүр царай	10 сек.
4	Ширүүн элсэн шуурганд худаг эрж байгаа Дугар, Өлзий хоёр ; Дугар шуурганд морио алдана.	2 мин. 3 сек.
5	Амь үрэгдсэн Өлзийгийн анисагыг дарж нүүрэн дээр нь малгайг нь тавьж буй Дугар	1 мин. 11 сек.
6	Худагт хүрч ирээд амсхийх Дугар, Өлзий хоёр ; Толгойн цаана байрлаж байгаа япон цэргүүдийг олж харна.	4 мин. 37 сек.
7	Худагт ойртож ирэх япон цэргүүд ; Дугар тээнэгэлзэж байгаад Өлзийг үлдээж ангидаа хэл хүргэхээр морины хар хурдаар давхин одно.	5 мин. 2 сек.
8	Ойртож ирэх япон цэргүүдийн хөлийн дүрс	4 сек.
9	Ойртож ирэх япон цэргүүдийн хөлийн дүрс	5 сек.
10	Ойртож ирэх япон цэргүүдийн хөлийн дүрс (удаашруулсан)	14 сек.
Бүгд		15 мин. 34 сек.

1. Дээр дурдсанаар киноны эхлэлийн үзэгдэлд гарна.

2. Дугар, Өлзий нар болон ойр хавийн арваад залуучуудыг цэрэгт зарлан дуудаж, ирцийг бүртгэсний дараа нутгаасаа үдэж мордуулж байгаа үзэгдэл. Ийм үзэгдэл өмнөх дайны сэдэвтэй кинонд цог жавхлантай, эрэлхэг үйл явдал байсан байж магадгүй. Харин тус кинонд бол нөхрийгөө үдэж мордуулсан залуу эхнэрийн цурхиран уйлах үзэгдлийг оруулж, эгэл хүмүүст тохиолдох дайн дажны бэрхшээл, эмгэнэл зовлонг үзүүлжээ.

3. Цэвэлийн гэрт ирж халамцуухан унтах Дугарын хар дарсан зүүд киноны үзэгдэлд гарна. Энэ үзэгдэлд Өлзий яагаад үхсэн нь арай тодорхой болоогүй л байна.



4. Худаг олж хамгаалах тушаалтай яваа Дугар, Өлзий хоёр замдаа хүчтэй элсэн шуургатай дайралдах үзэгдэл бөгөөд Дугар шуурганд морио алдаж алдаа гаргана. Энэ нь хожим япон цэргийн бүслэлтээс ганц хүн л мултран гарах муу үр дагаварт хүргэнэ. Шуурга намдаж худгийн хавьд нэгэнт ирснийг мэдэж тэд баярлалдана.

5. Сандагаас “Чи миний аавыг алсан, мэдэв үү” гэж өөдөөс нь шууд улаан цагаан хэлэхийг сонссон Дугар модны дэргэд “Би Өлзийг алаагүй шүү дээ. Бурхан минь!” гэж өөрийгөө зэмлэн уйлах үзэгдлийн дараа гарна. Амь үрэгдсэн Өлзийгийн анисгыг дарж малгайгаар нь нүүрийг нь бүтээж “Хоёулаа хамт явъя гэж би хэлсэн шүү дээ” гэж Дугар шивнэнэ.

6. Дөрөвдүгээр үзэгдлийн үргэлжлэл бөгөөд худагт хүрч ирсэн Дугар, Өлзий хоёр ус ууж амныхаа цангааг гаргаад толгойн цаана байрлаж байгаа япон цэргүүдийг олж харах үзэгдэл юм.

7. Зургадугаар үзэгдлийн үргэлжлэл бөгөөд япон цэргүүдийн байдлыг дурангаар харж Дугар, Өлзий хоёр ингэж маргалдана. Өлзийгийн амь эрсдэхтэй холбогдолтой чухал хэсэг болохоор жаахан уртдасан ч тэр чигээр нь иш татъя⁽⁹⁾.

--- Өлзий буцъя. Хоёулхнаа яах юм бэ? Ангидаа очиж мэдэгдье. Хараагүй байгаа дээр нь эртхэн буцъя. Тэгэх үү?

--- Энэ өндөрлөг, энэ худаг чинь манайх, манайх гэдгийг ойлгож байна уу, чи? Тэгэхлээр дайсанд алдаж яасан ч болохгүй.

--- Үгүй ээ, Өлзий. Чи чинь, чи юу яриад байгаа юм бэ? Аа. Тэгээд яах гэж. Чи өөрөө бод л доо. Аа. Чи эрүүл ухаантай байна уу, үгүй юу? Тэд хэдүүлээ байна, хараач. Аан. Өлзий, явъя, явъя.

--- Дуугүй болооч.

Хоёулаа ярилцаж байтал япон цэргүүд тэдэн рүү жагсаж ойртож ирнэ.

--- За, болохоо байлаа. Одоо ингээд өнгөрчээ. Цаадуул чинь яг наашаа ирж явна. Одоо яахав?

--- Тэгэхлээр ингэнээ. Нэг нь явж ангидаа хэл хүргэе.

--- Хэн?

--- Чамаас өөр хэн гэж байна? Бушуу яв!

Дугарыг тээнэгэлзэж байтал Өлзий хашгирна.



--- Үгүй ээ, чи юу гөлрөөд суучихав аа? Түргэлээч ээ!

--- Хөөш, Өлзий. Хоёулаа явъя л даа, тэгэх үү? Хоёулаа явъя л даа, тэгэх үү?

--- Би чамайг яв гэж тушааж байна. Хэрэв тушаал биелүүлэхгүй бол уу! Яваач!
Өлзий Дугарыг заамдаж аваад түлхжээ.

--- Мэдлээ.


Ингээд Дугарыг морьтой нуугдаж явах гэж байтал Өлзийгийн байрлаж буй толгойн ар талаас нь дайснууд мөлхөцгөөж байгаа нь харагдана. Дугар мориноосоо бууж буу шагайн хэвтээд шивнэнэ.

--- Үгүй, ингэхэд арван хүний өөдөөс чи яах юм бэ? Чамайг дор нь нам буудчихна. Буудаад яах юм бэ? Өлзийг ч алаад намайг ч ална. Хэл хүргэсэн ч юм байхгүй. Тэгснээс...

Дугар морины хар хурдаар давхин одно.

8,9,10. Цэвэлийн амаржсаныг мэдэгдэхээр Сандагийг гэрийн гадаа зогсож түмпэн нүдэж байгааг нь гайхан хараад “Хүү минь, үр минь” гэж шивнэж байгаа Дугарын толгойд эргэлдэх үзэгдэл юм. Ойртож ирэх япон цэргүүдийн хөлийн дүр зураг Дугарын толгойноос салдаггүй улигт бодол болж түүнийг зовоож тарчлаана. Энэ нь Дугарын амиа хорлох нэг түлхэц болсон гэж хэлж болох юм.

Үүнээс гадна тус кинонд Сандагийн дурсамжийн үзэгдэл хоёр удаа гарах бөгөөд киноны үйл явдалд чухал байр суурь эзлэнэ. Нэг нь Сандаг аав ээжтэйгээ наадамд оролцсон хөгжилтэй дурсамжийн үзэгдэл (2 мин. 3 сек.) юм. Бас нэг нь цэргээс халагдсан Дугар нутагтаа буцаж ирээд талийгаач Өлзийгийн гэрт найр хийж байгаа үзэгдэл (4 мин. 10 сек.) бөгөөд Сандагийн хувьд аавын үхлийг мэдэж авсан эмгэнэлтэй дурсамжийн үзэгдэл ч гэж болох юм.



Наадмын үзэгдэлд Сандагийг аав ээжтэйгээ гурвуулаа сууж айраг ууж байтал Дугар тааралдаж, уралдаанд түрүүлсэн Сандагийн морийг зарахыг гуйх хэсэг нь тэд нарын хожмын хувь заяаг далд харуулж байгаагаараа нь сонирхолтой байна⁽¹⁰⁾

--- За хөө, Өлзий, чи хэдээр өгөх юм?

--- Юуг тэр вэ?

--- Юу юуг тэр гэж. Яагаав. Буурал морио.

--- Аа золиг гэж дээ. Би чамайг авгайгаа зарчих гэж

байгаа юм байх гэж бодлоо.

Найр хийж байгаа үзэгдэлд Дугарыг аавын үхэлтэй ямар нэгэн холбоотой гэсэн сэжиглэл Сандагт төрсөн бололтой. Найр дээр халсан Дугар цугларсан хүмүүстэй хэрэлдэнэ⁽¹¹⁾

--- Бид хоёрын харж байсан худаг нэг тийм элстэй толгойн ар дээр байсан юм л даа. Тэгээд яахав. Бид хоёр хоёулхнаа байлаа шүү дээ. Та нар бод л доо. Таван машин япон бид хоёрыг бүслээд галлаж гарах нь тэр. Яахав, анги руугаа хэл хүргэхээр давхилаа. Тэгээд бүслэлт дундаас арай гэж нэг юм гараад л ...

--- За, чи битгий худлаа яриад бай. Муу эр дайнд хөөрнө гэгчээр. Эртүүд л хоёр машин байсан чинь хэдүйдээ таван машин болчихов?

--- За, чи зүгээр, битгий донгосоорой, мэдэв үү. Цаанаас нь гурав гараад ирсэн юм чинь, яах юм. Чамайг энд эхнэрийнхээ өвөрт хэвтэж байхад би ... би цусаа асгаруулж явсан хүн, гайгүй байлгүй. Тэгээд яахав, сум исгэрээд л би ч анги руугаа хэл хүргэхээр давхилаа. Тэгээд арай гэж нэг муу юм хэл хүргээд ирсэн чинь хөөрхий муу Өлзий ...



Тэгж хэлээд Дугар Сандагийг дуудаж аавынх нь дурсгал дурсамж болох “Халхын голын байлдааны медаль”-ийг гардуулна. Мөн найр тараад буцах замд явсан хоёр согтуу хүн хоорондоо ярилцахыг Сандаг голын захад сууж юу ч анзаараагүй дүрээр сонсоно.

--- Хөөш, би нэг юм бодлоо. Энэ Дугар дуугүй царайлчихаад их эд байна шүү. Эднийд хар бор ажлыг нь хийж, эсгий ноосыг нь болголцож өгөөд байсан чинь байна шүү дээ. Цаанаа энэ Цэвэлтэй учиртай

байсан байна шүү. Цэвэл ч сайхан хүүхэн шүү.

--- Цаадах чинь арай энэ Өлзийг өөрөө нухчихсан юм биш байгаа даа.

--- За, арай ч дээ. Цэвэлтэй суусан хүн хожно доо.

Үүнийг сонссон Сандаг юу гэж бодсоныг бүү мэд, харин Цэвэлтэй яриа өрнүүлэх Дугарын шивнэх дууг гэрийн гаднаас сэм сонсоод улам улам сэжиглэсэн нь дамжиггүй.

4. “Сүүдэр” кино эх орны төлөө байлдах дайчин зоригийг бадруулах дайны кино мөн үү?

Социализмын үед гарсан эх орны төлөө дайтаж байлдах урам зоригийг бадруулах эрэлхэг баатарлаг дайны кино, жишээлбэл “Дайсны цэргүүдээ сонсоцгоо” (1971), “Говь Хянганд тулалдсан нь” (1981), “Зарлаагүй дайны оршил” (1984) гэх мэтийн “Монгол кино” үйлдвэрийн болон, эсвэл “Мосфильм” студитэй хамтран бүтээсэн дайны сэдэв агуулгатай кинотой харьцуулахад “Сүүдэр” кинонд Хүйтэн дайны үед тогтсон “Зөвлөлт Холбоот Улс пролетарийн интернационализмын зарчмыг удирдлага болгон өөрийн интернационалист үүргээ биелүүлж Монголын ард түмнээс японы түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэлд (=Халхын голын дайнд) зэвсэгт хүчээрээ тусласан нь манай эх орны эрх чөлөө, тусгаар тогтнолыг аварсан бөгөөд алс дорно зүгт империализмын эсрэг хүчний байр суурийг бэхжүүлэхэд нөлөөлөв” ⁽¹²⁾ гэсэн түүхэн үзэл суртал өөрчлөгдөж, дайн дажин гэдэг нь хүний амьдрал, хувь заяанд ямар ноцтой нөлөө үзүүлдэг болох тухай нийтлэг үзэл санаа ил гарч байгаа нь мэдрэгдэж байна. Цэвэлийн аав ээж (Базар, Долгор) хоёрын ярианаас түүний илрэлийг мэдэж болно ⁽¹³⁾.

--- (Базар) Тэр Дугар гэдэг нэг юм хүний нүүр ч эгцэлж харж чадахгүй шүү. Явдал нь хүртэл үүр шөнөөр. Ямар юмаа дуурайчихсан.

--- (Долгор) Зайлуул, дайн дажинд яваад л тийм болчихож. Уг нь хүнд тусархаг сайн хүү байгаа юм. Дайн гэж бузар явдал, цэгээн чулууг хагалж цагаан сэтгэлийг харлуулдаг хойно, одоо яая гэхэв дээ.



Дугарын ой тойнд байн байн илэрч түүнийг зовоодог дайны дурсамж хэдийгээр жигшүүрт муухай

үйл явдал байсан ч дээрх үзэл суртлыг дэвшүүлэхийн тул дүрсэлсэн биш, харин хувь хүний сэтгэл санаанд дайны хүнд хүчир ямар ч өршөөл энэрэлгүй ул мөрөө үлдээдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл тус кино Халхын голын дайныг сэдэв болгон авч харуулсан боловч түүнээс илүү нийтлэг дайн дажны “эмгэнэлт үйл явдал”-ыг дүрсэлсэн кино болно. Мэдээж, тулалдаанд Өлзий ганцаараа амь үрэгдсэн ч үхэхээс өмнө “нүдний шилтэй” япон офицерыг бууны жадаар сүлбэж алж амжсаныг үзээд (дараа нь хүрч очсон монгол цэргүүд алсан ч байж болох юм) монгол үзэгчид мэдрэлийн катарсис хүлээж авах нь дамжиггүй. Гэвч тус кино Японы эсрэг суртал ухуулгын кино ч биш, дайтаж тэмцэх урам зоригийг бадруулах кино ч биш, харин дайн дажныг эсэргүүцсэн дээд зэргийн уран сайхны кино гэж хэлж болох юм.

Кино хамгийн сүүлд өөрийгөө буудаж амиа хорлох гэж байсан Дугарыг Сандаг санамсаргүй олж аваад гэрлүүгээ Дугарыг чирж яваа үзэгдлээр төгсөж байна. Саяхан төрсөн дүүгээ ч бодсон байх. Тэр үедээ Сандагийн уйлан хашгиран хэлсэн үгэнд анхаарал хандуулъя⁽¹⁴⁾.

--- Дугар ахаа! Гэртээ харья л даа. Гэртээ харья. Та яаж байна?



Дээрх өгүүлбэрт “гэр” хэмээх үгэнд өгөх-оршихын тийн ялгалын дагавар “-т” залгаж, дараа нь ерөнхий хамаатуулахын “-ээ” дагавар залгасан байна. Өөрөөр хэлбэл дээрх өгүүлбэрийн тэр “гэр” бол Дугарын “өөрийн нь гэр” гэсэн санааг илэрхийлж буй юм. Ийнхүү Сандаг Дугарыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч нэг гэр бүл болно. Өөрөөр хэлбэл Сандаг Дугарыг “өөрийн гэр”-лүүгээ чирж яваа үзэгдэл Дугарыг хар сүүдрээс гэрэл гэгээ рүү, үхлээс амьдрал руу авч явж

байгааг бэлгэдэж байна гэж үзэж болох юм.

Бас тус киног бүтээсэн 1986 он бол ардчилалын өмнөх үе байсан боловч аажмаар өөрчлөлт шинэчлэл эхэлж байсан үе бөгөөд тус кино японыг үзэх монголчуудын үзэл нааштай болж эхлэхийг шууд бус аргаар бэлгэдсэн байна гэхэд арай хилсдэхгүй болов уу.

Төгсгөлийн үг

“Сүүдэр” киноны нийтийн хүртээл болсон 1986 оноос хойш дунд нь ардчиллын хугацаагаа хавчуулсан 19 жилийн дараа буюу 2005 онд Монголын алдартай рок поп хамтлаг болох “Камертон” хамтлагийн ахлагч Доржсүрэнгийн Болд (1978-) анхны бие даасан соло цомог “Хайрын хүч”-ийг гаргав. Тус цомгийн дотор “Чамдаа хэлье” хэмээх тийм айхтар онцгой зүйлгүй, жирийн хайр дурлалын сэдэвтэй дуу байдаг юм. Харин тэр дууны видео клипийг Улаанбаатар хотод телевизээр үзэх санамсаргүй тохиолдол надад тааралдаж, маш их гайхсаныг санаж байна. Энэ бол япон (Болд өөрөө тоглосон), монгол хоёр залуу тус тусын нутагтаа эхнэр нялх хүүхдээ үлдээгээд нөхөдтэйгөө хамт Халхын голын байлдааны талбар бололтой газар очиж, хоорондоо сүүлийн ганц хүн болтол тулалдах дүрийг дурсамжийн хэлбэрээр харуулсан дөрөвхөн минутын богино бүтээл юм. Япон, монгол хоёр залуугийн ар талд хайрт гэр бүлийнхний нь амьдарч байгаа энх амгалан орон нутаг нь байдаг бөгөөд оюун санааныхаа тулгуур гэж хэлж

болох хүн (япон залуугийн хувьд самуурайн багш, монгол залуугийн хувьд шарын шашны дээд лам) бий. Тийм хүмүүсээс албадан хагацуулж байлдааны талбайд дайчлагдаж бие биеэ алахаас өөр аргагүй хатуу хувь заяа нь өнөөх залуучуудад дайралдсан байна. Энэ нь япон, монгол хоёр талд ав адилхан байна. Эл видео клип амьд үлдсэн хоёр залуугийн бүр ойроос буудалцаж унах хөдөлгөөнгүй үзэгдлээр төгсөж байна. Үүнд нөхөр дайсан хоёр, ялагч ялагдагч хоёр гэсэн үзэл бодол огт байхгүй. Цомогт нэрлэсэнчилэн, “хайрын хүч”-инд итгэж хайрт хүмүүсийн төлөө тэмцэх дүр зураг л байгаа юм. Мэдээж, муу санааны үүднээс үзэхэд тус клипт гарах хувцас хунар (ялангуяа японы үндэсний хувцас “кимоно”), багаж хэрэгсэл зэрэг тухайн цаг үеийнхний шинжилгээ судалгаа хааш яаш байна, түүхэн үнэнд нийцэхгүй байна гэж шүүмжлэхэд амархан боловч, япон хүн, монгол хүн хоёрыг яг л адилхан байр сууринаас дүрсэлж байгаагаараа шинэ сэргэг болжээ гэж хэлж болох юм. Миний бие урьд монгол романд дүрслэгдсэн япон хүний дүрийн нааштай өөрчлөлтийн тухай бичиж байсан⁽¹⁵⁾. Түүнээс хойш видео клипийн ертөнцөд Халхын голын дайны талбар болгосон тайзан дээр япон хүнийг иймэрхүү байдлаар дүрслэн үзүүлэх болсон нь шинэ зүйл байна.

Зүүлт

- (1) 2009 оны 7-р сард Улаанбаатар хотод хуралдсан “Халхын голын тулалдаан (Номонханы үйл явдал) дэлхийн түүхэнд --- Өнгөрснийг мэдэх, ирээдүйг хэлэлцэх нь ---” хэмээх олон улсын симпозиумийн “Халхын голын тулалдаан (Номонханы үйл явдал) -тай холбогдолтой хэвлэл мэдээлэл, уран зохиол, кино, хөгжим, дүрслэх урлаг” хэмээх 3-р салбар хуралдаанд нэрт кино найруулагч Гомбожавын Жигжидсүрэн (1942-) гуайн тавьсан “Халхын голын тулалдааны тухай уран сайхны кино” гэдэг илтгэлээс иш татав. Г.Жигжидсүрэн гуайн хэлснээр бол Гонгор баатрын тухай киноны нэр “Анхдугаар хичээл” биш, “Анхны хичээл” нь зөв байна гэнэ.
- (2) “Анхдугаар хичээл (Анхны хичээл)” киног зохиож найруулсан Төмөрийн Нацагдоржийг Дашдоржийн Нацагдоржоос (1906-1937) ялгахын тулд тухайн үед “Бага Нацагдорж” гэж нэрлэж байжээ. Тэрбээр 1926-1929 онд Германы Викерсдорф (Wickersdorf) дахь дунд сургуульд суралцаж байгаад нутагтаа буцаж ирсний дараа Улаанбаатар хотын багшийн сургууль зэрэг сургуулиудад багшлахын хамт яруу найрагч, кино найруулагчаар ажиллаж байжээ. “Анхдугаар хичээл (Анхны хичээл)” киноноос гадна “Норжмаагийн зам”(1938), “Сүрэг чоно”(1939), “Амьдралын дайсан”(1941) зэрэг киног найруулжээ. Түүний дараа “Хил дээр гарсан хэрэг” киногоо бүтээж байсан 1942 оны 6-р сарын 9-нд Улаанбаатар хотын орчимд “Германы тагнуул” хэмээх хилс хэргээр сэжиглэгдэн баривчлагдаж, 10 жил хорих ял заагджээ. Тэгээд 1949 онд Улаанбаатарын Төв хорих газраас Зүүн хараагийн засан хүмүүжүүлэх ангид шилжүүлэн улмаар спирт заводын уурын зуухны галчаар ажиллаж байгаад 1958 онд суллагдсан гэнэ (Наваан, Солонго 2005, хууд.35-36.).
- (3) Тус өгүүлэлд хэрэглэсэн видео хуурцаг 1987 оны 8-р сарын 20-нд “Монгол Телевиз”-ийн “Уран сайхны кино” хэмээх хөтөлбөрөөр нэвтрүүлсэн “Сүүдэр” киног гэрийн видео тоглуулагчаар бичиж авсныг эх болгосон юм. Мөн киноны видео бичлэгийг монтажийн хуудастай (Сүүдэр 1986) тулгаж үзэхэд үг ярианд нь

нэлээд зөрөө байгаа тул видео бичлэгт үндэслэж монтажийн хуудасыг засч залруулсныг текст болгон иш татав. Бас видео бичлэгийг DVD-д буулгаж хийсэн хөдөлгөөнгүй зураглалаас зарим зургийг авч оруулав.

(4) Жигжидсүрэн, Цэцэг 2005, хууд.168,301,339,387,397. ; Зандраабайдий 2008, хууд.89. ; Цолмон 1995, хууд.102-103.

(5) Баярсайхан 2009. ; Жигжидсүрэн, Цэцэг 2005, хууд.302,348,392. ; Цолмон 1995, хууд.102-103.

(6) Сүүдэр 1986, хууд.32-33.

(7) Сүүдэр 1986, хууд.48.

(8) Сүүдэр 1986, хууд.48-49.

(9) Сүүдэр 1986, хууд.43-45.

(10) Сүүдэр 1986, хууд.20.

(11) Сүүдэр 1986, хууд.26-27.

(12) БНМАУ-ын түүх III 1969, хууд.376.

(13) Сүүдэр 1986, хууд.6.

(14) Сүүдэр 1986, хууд.49.

(15) Окада 2001(2004).

Номзүй

[Баярсайхан 2009] : М.Баярсайхан, “Зуу дахь хавраа угтаж буй МУИС-ийн Хүндэт профессор”, *“Өнөөдөр”* сонин, №011(3088), 2009.02.16. ; *“Зуун насыг зооглож зургаадай таяг тулж буй Я.Шаарийбуу багштан”*, Улаанбаатар, МУИС-ийн Хэвлэх үйлдвэр, 2009, хууд.134-142.

[БНМАУ-ын түүх III 1969] : БНМАУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэн, *“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх”*, Гутгаар боть (Нэн шинэ үе), Улаанбаатар, Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1969.

[Жигжидсүрэн, Цэцэг 2005] : Г.Жигжидсүрэн, Д.Цэцэг, *“Монгол киноны нэвтэрхий толь”*, Улаанбаатар, “СОДПРЕСС” ХХК, 2005.

[Зандраабайдий 2008] : Х.Зандраабайдий, *“Монголын зохиолчдын намтрын лавлах бичиг”*, Улаанбаатар, “БЕМБИ САН” ХХК, 2008.

[Наваан, Солонго 2005] : Ц.Наваан, Ж.Солонго, *“Монголын баримтат киноны түүхэн товчоон”*, Улаанбаатар, “Номос пресс” хэвлэлийн газар, 2005.

[Окада 2001(2004)] : К.Окада, “Монгол романд дүрслэгдсэн Японы олзлогдогсод”, *“Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг”*, Боть XVIII (178), МУИС-ийн Монгол Хэл Соёлын Сургууль, Улаанбаатар, 2001, хууд.58-75. ; *“MONGOLICA”*, Vol.15(36), International Association for Mongol Studies, Улаанбаатар, 2004, хууд.110-125.

[Сүүдэр 1986] : *““Сүүдэр” уран сайхны киноны монтажийн хуудас”* (Машиндмал эхийн хуулбар), I-IX бүлэг, Монтажийн хуудас гаргасан П.Нарантуяа, В.Одгэрэл, Улаанбаатар, 1986, 49 хууд.

[Цолмон 1995] : Д.Цолмон, *“Монгол кино”*, Улаанбаатар, Хөх хот, “Эрүүл Энх” хэвлэлийн газар, 1995.

х

х

х

х

Тус өгүүлэл 2009 оны 7-р сард Улаанбаатар хотод хуралдсан “Халхын голын тулалдаан (Номонханы үйл явдал) дэлхийн түүхэнд --- Өнгөрснийг мэдэх, ирээдүйг хэлэлцэх нь ---” хэмээх олон улсын симпозиумд тавьсан илтгэлдээ нэмэлт засвар оруулсан болно.

(2009.08.18., Токио хот)

SUMMARY

The movie “Shadow (Suuder)” was first screened among the public in 1986. This movie was written by Sorogdogiin Jargalsaikhan (1957-2007), who was a D.Natsagdorj’s named Prize writer and was directed by Mongolian State Prize cameraman/director Begziin Baljinnyam (1943-). Mongolian Honoured actor Gombyn Ravdan (1952-) portrayed the leading role of Dugar, who evokes the harsh days of the Khalkh River War. Mongolian State Prize actor Tsegmediin Tumurbaatar (1956-) played the role of his friend Ulzii who is from the same motherland but sadly dies on the battlefield of the Khalkh River War. Tsevel, the woman who starts having sexual relationships with Dugar after the death of her husband Ulzii and gets pregnant was played by actress Dorjiin Dolgorsuren (1958-) and Sandag, the only son of Ulzii and Tsevel, who despises Dugar was played by T.Otgonbaatar.

The directors of photography were B.Baljinnyam and Dechinravdangiin Balchinpurev (1950-) and the art director was Puntsagiin Sosorbaram (1947-). The movie music was composed by Mongolian twice-declared State Prize composer Natsagiin Jantsannorov (1948-) and the historical background of the movie was advised by Prof. Yadamsurengiin Shaariibuu (1909-2009), who was a Mongolian Honoured teacher, honorary professor of the National University of Mongolia and former army colonel of “Manj Go (Manchukuo)”.

There are many heroic war movies that were made during the socialist period, which were intended to exalt the fighting spirits of the nation. Compared to movies like “Listen Here, You Enemy Soldiers” (1971), “The Battles in Gobi Desert and Khingan Mountains” (1981) and “The Beginning of the Undeclared War” (1984) which were made by “Mongol Kino” or collaborated with “Mosfilm”, the movie “Shadow” differs in a way that it erases the historic ideology made up in the days of the Cold War, that “the Khalkh River War was a battle where Mongolia allied with the Soviet Union to defeat the aggression of Japanese militarists and protected the independence of the Mongolian People’s Republic” and instead we can see that it tries to depict the common understanding of how wars and conflicts can severely affect the lives and destinies of people.

Even though the ill memories of war that upset Dugar every so often were cruel and ruthless, the film was not intended to promote the above ideology but to express how the brutal and merciless events of war can leave a haunting mark on one’s personal mentality. Of course, even though Ulzii was the only one who lost his life during the battle, the scene where he had killed the Japanese officer with his bayonet before dying is sure to put Mongolian viewers into mental catharsis.

The film finishes with the scene of Sandag finding Dugar, who was trying to commit suicide with his gun, and dragging him home where his newborn baby lies. We could conclude that this is a depiction of Dugar being pulled from a dark shadow to light and from death to life. Also, since this period all types of transformations started and it wouldn’t be too wrong to say that it symbolizes the gradual diminishing of Mongolians’ dislike towards Japan.